



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх дуусгавар болгох хүсэлт ирүүлсэн 1 (Нэг) иргэний газар эзэмших эрхийг хавсралтад зааснаар дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх нь дуусгавар болж байгаа иргэнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариу мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/187 дугаар захирамжийн У.Баяржаргалд хамаарах заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД